

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САН

Хөтөлбөрийн товч танилцуулга

Боловсролын зээлийн сан нь монгол улсын боловсрол, шинжлэх ухаан, аж үйлдвэр, соёл, нийгмийн салбарт хувь нэмрээ оруулах, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай үндэсний хүний нөөцийг бэлтгэх зорилгоор дэлхийн шилдэг их, дээд сургуульд монгол хүн суралцахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх сан болно. Нийт элсүүлэх оюутны тоо 40-50.

Шалгуур үзүүлэлт

- **Ахисан түвшний хөтөлбөр(Хугацаа: 4-5 дүгээр сар)**

Тэтгэлгийн хугацаа	Магистрын зэрэг Докторын зэрэг	1-2 жилийн хугацаатай
Шалгуур үзүүлэлт	<p>Сонгон шалгаруулалтанд оролцох хүн нь доор бичсэн шалгууруудыг хангах ёстой;</p> <ol style="list-style-type: none">1. Зарлагдсан мэргэжлийн чиглэлийн дагуу бакалавр (магистрантурт өргөдөл гаргагч), магистр (докторантурт өргөдөл гаргагч)-аас доошгүй боловсролын зэрэгтэй2. Өмнө Сургалтын төрийн сангийн зээл, тэтгэлгээр гадаад оронд бакалавр, магистрантурт сурсан иргэн дараагийн шатны сургалтыг олгохгүй.3. Дипломын сурлагын голч дүн нь 3,25 ба түүнээс дээш4. Мэргэжлээрээ 3 ба түүнээс дээш жил ажилласан5. Судалгаа шинжилгээний ажлын туршлагатай6. Тухайн суралцах сургуулийн сургалтын гадаад хэлний шаардлагыг бүрэн хангасан7. Гадаад улсын нэр хүндтэй шилдэг их сургуулийн магистрантур, докторантурын үндсэн сургалтад дээр дурдсан мэргэжлийн чиглэлийн дагуу шууд суралцахаар элссэн, эсвэл суралцах албан ёсны урилга авсан иргэн,8. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Сонгодог урлагийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд Болгар, Итали, Франц зэрэг улсад сонгодог урлагийн чиглэлээр магистрантур, докторантурын үндсэн сургалтад суралцах эрх авсан иргэн бүртгүүлэн оролцох эрхтэй.9. Энэхүү санхүүжилтэд хамрагдах гадаадын шилдэг их сургуулийн нэрстэй дараах холбоосоор орж танилцана уу:	

Сонгон шалгаруулалтын үйл явц

1



Цахим өргөдөл
(www.esis.edu.mn/grant холбоосоор
хандаж цахим
өргөдөл бөглөн,
баримт бичгийг
өргөдөлд татаж
оруулна)

2



Боловсрол, соёл,
шинжлэх ухаан,
спортын яамнаас
томилсон их сургууль,
эрдэм шинжилгээний
болон мэргэжлийн
байгууллагын
төлөөллөөс бүрдсэн
шалгалтын комисс нь
шалгаруулалтыг
баримт бичигт дүн
шинжилгээ хийх,
ярилцлага хийх
хэлбэрээр зохион
байгуулна.

3



Шалгарсан Монгол
улсын иргэн
Боловсролын зээлийн
сангаас \$16000 хүртлэх
санхүүгийн дэмжлэг
авах боломжтой болно.



Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол

- <http://www.elf.mn>